



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/251

Хэрлэн сум

Гамшгаас хамгаалах Команд штабын  
сургууль зохион байгуулж, хөрөнгө  
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.5, 32 дугаар зүйлийн 32.1, 32.1.1, 32.1.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, сум орон нутгийн гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах Команд штабын сургуулийг 2023 оны 5 дугаар сарын 08-аас 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдөр хүртэл хугацаанд Дадал суманд зохион байгуулсугай.

2. Тус сургуульд шаардагдах 3,543,590 (гурван сая таван зуун дөчин гурван мянга таван зуун ерэн) төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлээс хамгаалах сангийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Команд штабын сургуулийг зохион байгуулах комиссыг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Дээрх арга хэмжээг тусгай удирдамж төлөвлөгөөний дагуу сахилга хариуцлага, чанарын өндөр түвшинд зохион байгуулж, дүнг танилцуулахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны  
дугаар сарын 25-ны өдрийн  
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

**ГАМШГААС ХАМГААЛАХ КОМАНД ШТАБЫН СУРГУУЛЬ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

Комиссын дарга:	Л.Батсайхан	Аймгийн Засаг даргын орлогч
Сургуулийн удирдагч:	Б.Бат-Эрдэнэ	Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, ахмад
Нарийн бичгийн дарга:	Г.Золжавхлан	Ангиллын сургалт, сурталчилгаа урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч
Гишүүд:	Ц.Гэрэлмаа	Зооноз өвчин судлалын төвийн дарга
	Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга
	О.Ган-Очир	Цагдаагийн газрын Нийтийн хэв журмыг хамгаалах тасгийн дарга, Цагдаагийн ахмад



Аймгийн Засаг даргын 2023 оны  
04 дугаар сарын 25-ны өдрийн  
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

**ГАМШГААС ХАМГААЛАХ КОМАНД ШТАБЫН СУРГУУЛЬ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг: Зорилго:

Дадал сумын гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлыг хангуулж тохиолдож болзошгүй ой, хээрийн болон объектын гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, хариу арга хэмжээг цаг алдалгүй шуурхай зохион байгуулах, сумын шуурхай штаб, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулж мэдлэг, чадвар олгоход чиглэгдэнэ.

Хоёр: Сургалтанд хамрагдах сум, зохион байгуулах хугацаа:

Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг Дадал суманд 2023 оны 5 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд зохион байгуулна.

Гурав: Зохион байгуулах ажил.

- Сургалт зохион байгуулах байр танхимыг бэлтгэх.
- Шуурхай штаб, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бэлэн байдлыг шалгах.
- Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн техник хэрэгсэл багаж зэвсэглэмжийг шалгах.
- Онцгой комисс, бие бүрэлдэхүүнийг 1 дүгээр цагийн байдал дээр ажиллуулах.
- Онцгой комисс, бие бүрэлдэхүүнийг 2 дугаар цагийн байдал дээр ажиллуулах.
- Онцгой комисс, бие бүрэлдэхүүнийг 3 дугаар цагийн байдал дээр ажиллуулах.
- Орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийлгэх
- Гамшгаас хамгаалах чиглэлээр орон нутгийн болон сумын Онцгой комисс болон мэргэжлийн ангийн дунд бүтээлч ажил хийх.
- Команд штабын сургуулийг дүгнэх, хаах.


Дөрөв: Сургуулийн бэлтгэл ажил хангах ажлыг хэсэг:

Ажлын хэсгийн ахлагч:	О.Баярмагнай	Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, ахмад
Гишүүд:	Г.Золжавхлан	Ангиллын сургалт, сурталчилгаа урьдчилан

	сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч
Ч.Гантогтох	Хэрлэн сум дахь Эрэн хайх аврах салбарын дарга, хошууч
Д.Оюунбаатар	Гал унтраах автомашины жолооч, ахлах ахлагч

Тав:Дүнгийн талаар

Команд штабын сургуулийг зохион байгуулсан дүнг илтгэх хуудсаар бичиж аймгийн Засаг дарга, Онцгой комиссын хуралдаанд танилцуулах, цаашид анхаарах, зөрчил дутагдлыг засч арилгах талаар зөвлөмж, үүрэг даалгавар өгөх



Аймгийн Засаг даргын 2023 оны  
дугаар сарын 25-ны өдрийн  
дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

Команд штабын сургууль зохион байгуулахад  
шаардагдах зардлын тооцоо

Гамшгаас хамгаалах Команд штабын сургууль					
			Шатахууны зардал	Томилолтын зардал	Бусад зардал
1	Дадал сум	2023 оны 5 дугаар сарын 08-12 ны өдөр	Чингис - Дадал сум ирж очиход 540 км-т 97.2 л, дотор 50 км-т 10л нийт 106.2л 267.624 төг	Сургуулийн бэлтгэл хангах 4 хүн 5 хоног 1.280.000 төг	Шагнал 440.000 төг, бодлогын зураг 215.000 төг, Аннос 250,000 Нийт 905.000
			Чингис - Дадал сум ирж очиход 540 км-т 70л, дотор 50 км-т 10л нийт 82.6л 322.966 төг	Сургууль удирдах 6 хүн, 2 хоног 768.000 төг	
Нийт 3.543.590 төгрөг					